

ЗАВХАН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшин тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /е-топдоНа-аас татан авах/.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 17.30 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: zavhan@ndaatgal.mn цахим шуудангаар
- Холбоо барих утас: 99035513

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛЫН СУЛ ОРОН ТООГ
НӨХӨХ ТУСГАЙ ШАЛГАЛТЫН ЗАХИАЛГА

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаалын төрөл	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Албан тушаалын нэр	Сул орон тоо гарсан үндэслэл	Сул орон тоо гарсан шийдвэрийн он, сар, өдөр, дугаар
1	Завхан аймгийн Нийгмийн даатгалын газар	Тосонцэнгэл сумын Нийгмийн даатгалын тасаг	Дэс түшмэл, удирдах	ТЗ-6	Тосонцэнгэл сумын Нийгмийн даатгалын тасгийн дарга	Төрийн албанаас чөлөөлөгдсөн	Завхан аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 18- ны өдрийн ажлаас чөлөөлөх тухай” Б/72 дугаар тушаал